



МОНГОЛ УЛСЫН  
ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙДЫН  
ТУШААЛ

2020 оны 01 сарын 27 өдөр

Дугаар А/24

Улаанбаатар хот

Ажлын хэсэг байгуулах тухай


Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2, Хууль тогтоомжийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.2 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Донорын тухай хуульд оруулах нэмэлт, өөрчлөлтийн төслийн үзэл баримтлал, хуулийн төслийг боловсруулах ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг нэгдүгээр, ажиллах удирдамжийг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Донорын тухай хуульд оруулах нэмэлт, өөрчлөлтийн төслийн үзэл баримтлал, хуулийн төслийг боловсруулах ажлын хэсгийн үйл ажиллагааг удирдан зохион байгуулах, шаардлагатай тохиолдолд холбогдох мэргэжилтэн, бусад төлөөллийг татан оролцуулах, сайдыг тогтмол мэдээллээр хангаж ажиллахыг ажлын хэсгийн ахлагч, Эмнэлгийн тусламжийн газрын дарга (Я.Буянжаргал)-д үүрэг болгосугай.

3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн нарийн бичгийн дарга (Я.Амаржаргал)-д үүрэг болгосугай.

САЙД



Д.САРАНГЭРЭЛ

*Тогтох нь*  
*Бусад орны эрүүл мэндийн төлөөлөл*  
*Тусгай зориулалтын эмнэлгийн тусламжийн газрын дарга*  
*Я.Буянжаргал*  
*2020.01.27*

2020-A-tushaal

141200097

Эрүүл мэндийн сайдын 2020 оны 01...  
дүгээр сарын 01... өдрийн 01/24 дугаар  
тушаалын 1 дүгээр хавсралт

Донорын тухай хуульд оруулах нэмэлт, өөрчлөлтийн төслийн  
үзэл баримтлал, хуулийн төслийг боловсруулах  
ажлын хэсгийн бүрэлдэхүүн

Ажлын хэсгийн ахлагч: Я.Буянжаргал, Эрүүл мэндийн яамны Эмнэлгийн тусламжийн газрын дарга,  
Нарийн бичгийн дарга: А.Бархас, Эрүүл мэндийн яамны Эмнэлгийн тусламжийн газрын Донорын тусламж, үйлчилгээний асуудал хариуцсан мэргэжилтэн,  
Ажлын хэсгийн гишүүд: М.Ганзориг, Эрүүл мэндийн яамны Хуулийн хэлтсийн дарга,  
Н.Эрдэнэбаяр, Цус сэлбэлт судлалын үндэсний төвийн ерөнхий захирал,  
Ц.Алтантуяа, Эх, хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төвийн эмчилгээ эрхэлсэн дэд захирал,  
П.Батчулуун, Эрүүл мэндийн хөгжлийн төвийн Эс, эд, эрхтнийг шилжүүлэн суулгах үйл ажиллагааг зохицуулах албаны дарга,  
О.Сэргэлэн, Эрүүл мэндийн яамны Ерөнхий мэс засал судлалын мэргэжлийн салбар зөвлөлийн дарга, Улсын нэгдүгээр төв эмнэлгийн ерөнхий мэс заслын тасгийн эрхлэгч, Элэг шилжүүлэн суулгах багийн ахлагч,  
Д.Баян-Өндөр, Улсын нэгдүгээр төв эмнэлгийн Урологи-Андрологийн төвийн дарга, Бөөр шилжүүлэн суулгах багийн ахлагч,  
Н.Оюундэлгэр, Улсын нэгдүгээр төв эмнэлгийн Цусны эмгэг судлал, чөмөг шилжүүлэн суулгах төвийн зөвлөх эмч, цусны үүдэл эс, ясны чөмөг шилжүүлэн суулгах багийн ахлагч,  
Б.Бат-Ирээдүй, Улсын нэгдүгээр төв эмнэлгийн Эрхтэн шилжүүлэн суулгах төвийн дарга,  
М.Пүрэвтогтох, Эх, хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төвийн Үргүйдлийн нөхөн үржихүйн төвийн эрхлэгч,  
Цэ.Амаржаргал, Улсын нэгдүгээр төв эмнэлгийн захирлын ажлын албаны дарга,  
Я.Тогтохням, Цус сэлбэлт судлалын үндэсний төвийн хүний нөөцийн ажилтан, хуулийн зөвлөх,

Эрүүл мэндийн сайдын 2020 оны...  
дүгээр сарын... өдрийн... дугаар  
тушаалын 2 дугаар хавсралт

Донорын тухай хуульд оруулах нэмэлт, өөрчлөлтийн төслийн  
үзэл баримтлал, хуулийн төслийг боловсруулах  
ажлын хэсгийн ажиллах удирдамж

Нэг. Үндэслэл, хэрэгцээ шаардлага

Донорын тухай хууль анх 2000 онд батлагдаж, 2012, 2015 онуудад тус тус нэмэлт, өөрчлөлт орж, 2018 онд шинэчлэн батлагдсан. Тус хуулиар Монгол Улсын 25 насанд хүрсэн иргэн донор болж болно гэж заасан нь амьд донорын тоог цөөрөхөд хүргэж, эрхтэн шилжүүлэн суулгах хүлээх жагсаалтад бүртгэгдсэн 4 өвчтөн гадаад улсад эрхтэн шилжүүлж, 9 донор наснаас хамааралтай хасагдаж, 1 тохиолдолд хүлээж буй өвчтөн нас барсан байна. Мөн хүүхдэд эрхтэн шилжүүлэн суулгахад эцэг, эхийн нас 25 хүрээгүй байх тохиолдол элбэг байна.

Иймд амьд донорын насыг өөрчлөх шаардлагатай байна. Амьд донорын эгнээг өргөжүүлэх зорилгоор гэр бүлийн гишүүн донор болохоос гадна реципиентийн ураг төрлийн талаас донор байх боломжийг нэмэлтээр оруулах хэрэгтэй байна.

Тархины үхэлтэй донорын тоог нэмэгдүүлэх хэрэгцээ байсаар байна. Тухайлбал, 2019 оны байдлаар нэгдсэн бүртгэл мэдээллийн сангийн хүлээх жагсаалтад нийт 462 эмчлүүлэгч бүртгэлтэй байна. Үүнээс элэг шилжүүлэн суулгах шаардлагатай насанд хүрэгчид-99, хүүхэд-80, бөөр шилжүүлэн суулгах шаардлагатай насанд хүрэгчид-279, хүүхэд-4 тус тус бүртгэгдээд байна.

Тархины үхэлтэй донорын гэр бүлд оршуулгын тэтгэмжийг нэмэгдүүлэн олгох замаар тархины үхэлтэй донорын тоог нэмэгдүүлэх шаардлагатай байна.

Эрхтний наймаанаас сэргийлэх зорилгоор Монгол Улсын иргэн гадаадын иргэнтэй гэр бүл болсон тохиолдолд 2 ба түүнээс дээш жил хамтран амьдарсан тохиолдолд эрхтний донор болохыг зөвшөөрөх асуудлыг шийдвэрлэх хэрэгтэй байна.

Эс, эд, эрхтэн шилжүүлэн суулгах үйл ажиллагаатай холбоотой асуудлыг шийдвэрлэж байх Ёс зүйн хороог Эрүүл мэндийн яамны дэргэд байгуулах асуудлыг хуульд нэмэлтээр оруулах шаардлагатай байна.

Хоёр. Зорилго

Донорын тухай хууль, хуулийг дагаж гарсан эрх зүйн баримт бичгүүдэд бодлогын дүн шинжилгээ хийж, хуульд оруулах нэмэлт, өөрчлөлтийн төслийн үзэл баримтлал, хуулийн төслийг боловсруулах.

Гурав. Үйл ажиллагааны чиглэл:

- Хуулийн хэрэгжилт, хэрэгцээ, шаардлагыг урьдчилан тандан судлах;
- Хуульд оруулах нэмэлт, өөрчлөлтийн төслийн үзэл баримтлалыг боловсруулах,
- Хуулийн төслийг боловсруулах;
- Хуулийн төслийн үр нөлөөний үнэлгээ, зардлын тооцоог хийх;
- Хуульд оруулах нэмэлт, өөрчлөлтийн төслийн үзэл баримтлал, хуулийн төслийг Эрүүл мэндийн яамны Удирдлагын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэх;
- Хуульд оруулах нэмэлт, өөрчлөлтийн төслийн үзэл баримтлал, хуулийн төслийг хэлэлцүүлж, яамдаас санал авах.

Дөрөв. Үр дүн

Донорын тухай хуульд оруулах нэмэлт, өөрчлөлтийн төслийн үзэл баримтлал, хуулийн төсөл боловсруулагдан, хэлэлцүүлэгдсэн байна.